

**МАХН-ЫН III ИХ ХУРАЛ ХУРАЛДАХ ҮЕИЙН МАНАЙ  
УЛСЫН ГАДААД БАЙДАЛ: ТҮҮХ, ОРЧИН ҮЕ\*****Э. Пунцаг**

1924 онд Монгол Ардын Хувьсгалт Намын III их хурал хуралдах үеийн Ази, Алс Дорнодын олон улсын харилцааны нэг онцлог нь 1922 оны 2-р сард Вашингтонд гарын үсэг зурсан империалист 9 гүрний гэрээгээр тэдгээр улсууд хятадын «хаалгыг нээж» бүгдээрээ «тэгш бололцоотойгоор» ашиглах нэрийн дор хятадыг хуваан эзэмшихийг эрмэлзэж байв. 1922 оны «нээлттэй хаалга» бол 1982 онд хятадууд өөрсдөө нээсэн «хаалга»-тай ижил «дотогшоо» онгойдог биш боловч хаалгаар орогчид нь тэр үед ч, одоо ч АНУ, Англи, Франц, Итали, Япон юм.

Хятадад империалистууд дур зоргоороо аашилснаас болж, 1925 оны «5-р сарын 30»-ны сүрт эсэргүүцлийн хөдөлгөөн гарсан билээ. Үүнээс эхлэн империализм, түүний гар хөл болсон цэргийн эрхтний эсрэг хятадын 1925—1927 оны хувьсгал өрнөжээ.

Энэ үед хятад-зөвлөлтийн харилцааны асуудал зөвхөн хятадаар барахгүй бүхий л Алс Дорнодод чухал ач холбогдолтой зүйл болж байв. 1924 оноос ЗХУ-д болон мөн манай улсад «Хятадаас савраа тат!» гэсэн уриан дор хөдөлгөөн өрнөж байв. ЗХУ-ын үйлдвэрчний байгууллагын шугамаар байгуулагдсан «Хятадаас савраа тат!» хэмээх нийгэмлэг дэлхийн олон орны ажилчдад хандаж тийм хөдөлгөөн өрнүүлж Хятадад туслахыг уриалж байв. Зөвлөлтийн ард түмэн хөрөнгө мөнгө хуримтлуулахын зэрэгцээгээр сэтгэл санааны асар их дэмжлэг үзүүлж байв. Тухайлбал В. Маяковский 1924 оны 9-р сарын 21-нд «Известия» сонинд «Хятадаас савраа тат!» гэсэн гарчигтай хурц уран үгтэй, утга төгөлдөр шүлгүүдээсээ нийтлүүлж байжээ.

Тэр үед хятадын ард түмэнд сэтгэл санаа, эд материалын дэмжлэг үзүүлэх ажлыг манай оронд бас өрнүүлсэн юм. «Хятадаас савраа тат!» гэсэн уриан дор хөдөлгөөн өрнөж хуримтлалын фонд байгуулагджээ. 1925 оны 3-р сард засгийн газрын шийдвэрээр хятадын хувьсгалт цэрэгт зэр зэвсэг ачуулж, түүнчлэн ЗХУ-аас явуулсан зэвсгийг тээвэрлэж хүргэхэд манай улс тусалж байлаа. Коминтерний уриалгыг угтаж аваад олон нийтийн хурал цуглаан өрнүүлэх ажлыг МАХН зохион байгуулж байв. Үүний зөвхөн нэг жишээг дурдахад, Хятад, Марокко-

\*Энэхүү өгүүллийн үндэс нь зохиогчийн 1984 оны 11-р сард МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 60 жилийн ойд зориулсан онол-практикийн бага хуралд тавьсан илтгэл болно.

гийн дотоод хэрэгт империалистууд оролцож байгааг эсэргүүцэн Улаанбаатарын Нардом хэмээх соёлын ордонд 1925 оны 7-р сарын 2-нд хөдөлмөрчдийн цуглаан хийж байжээ.

Энэ үед Зөвлөлт Холбоот улс Хятадтай харилцаагаа сайжруулах талаар чухал санаачлага гаргаж байсны үрээр зөвлөлт, хятадын хооронд хэвийн харилцаа тогтоож, Хятадад 1925—1927 оны үндэсний хувьсгалын тохироо бүрэлдэж байсан ид үед Монгол Ардын Хувьсгалт Намын III их хурал хуралджээ.

МАХН-ын III их хурлын өмнө явагдсан зөвлөлт-хятадын хэлэлцээний үед Бээжингийн засгийн газар Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхийг үгүйсгэж, Монголд байрлаж байсан Улаан Цэргийн ангиудыг гаргах талаар зүй бус шаардлага тавьж бүхэлдээ Монголын эсрэг байр суурь эзэлж байв.

Монголын засгийн газрын хүсэлтийн үндсэн дээр тус улсад 1921 оноос хойш түр байрлаж байсан Улаан Цэргийн ангиудыг Монголоос гаргах, монгол-зөвлөлтийн 1921 оны 11-р сарын 5-ны хэлэлцээрийг хянаж үзэх тухай асуудлыг Бээжингийн засгийн газар Зөвлөлт Холбоот Улсын төлөөлөгч Л. М. Карахантай 1924 онд хийсэн хэлэлцээний үед хятад-зөвлөлтийн харилцааны асуудлыг зохицуулах болзлын нэг болгон тавьсаар байжээ.

Хятадын хэвлэлд бичиж байгаагаар хятад-зөвлөлтийн алив нэгэн хэлэлцээрийн урьдчилсан нөхцөл болгон Ар Монгол (БНМАУ-Э. П.)-ын өөртөө засах эрхээс татгалзах шаардлагыг Бээжингийн засгийн газар тавьж байсан байна. Бээжингийн засгийн газрын ийм хандлага нь хэлэлцээг бараг таслахад хүргэж байв.<sup>1</sup>

Манай улсын ерөнхий сайд Б. Цэрэндорж 1924 оны 1-р сард Ростагийн сурвалжлагчтай хийсэн ярилцлаганд: «одоо Монголыг автономийн байдалд буюу эзэн улсын харьяат болгож дахин өөрчлөх тухай яриа байж болохгүй нь мэдээж. Тийм ярианы цаг нь хэдийнээ өнгөрчээ. Монгол улсыг тусгаар тогтносон улс хэмээн хүлээн зөвшөөрөх явдал бол цорын ганц зам, тэгэхдээ сонирхогч бүх этгээдүүдэд тохирсон зам юм. Асуудлыг өөрөөр шийдвэрлэх нь хүнд бэрхшээл л гаргахаас өөр юунд ч хүргэж чадахгүй»<sup>2</sup> гэжээ.

Энэ үед Япон, Хятадын аль аль нь Улаан Цэргийн ангиуд Монголд байрлаж байсныг шалтаг болгож «Монгол бол тусгаар тогтносон улс биш, Зөвлөлт Холбоот Улс түүнийг колоничилж байна» гэх мэт суртал нэвтрүүлгийн кампани дэгдээж байсан нь үнэндээ монгол-зөвлөлтийн холбоо, найрамдлыг таслаж Монголыг өөртөө нэгтгэх буюу өөрсдөөсөө хараат болгох гэсэн Бээжин, Токиогийн уламжлалт бодлого байв. Ийм нөхцөлд монгол-хятадын харилцааг зохицуулж жуулчлах талаар Зөвлөлт засгийн газар цуцалтгүй чармайж байсан бөгөөд эцсийн эцэст хятадын олон нийтийн шаардлагаар 1924 оны 5-р сарын 31-нд «ЗХУ, Дундад Иргэн Улсын хоорондох асуудлыг зохицуулах ерөнхий зарчмын тухай» хэлэлцээрт гарын үсэг зурав.

Олон улсын империализм ЗСБНХУ-ын хүчин чадлын өсөлт, хятадын хувьсгалтай түүний ойртох нөлөөнд сэтгэл түгшиж, бололцоотой бүхий л аргаар саад хийж байсан 1924 оны үед зөвлөлт-хятадын хооронд харилцаа тогтсон нь империализмыг эсэргүүцсэн хятадын хувьсгалын эхлэлтэд чухал үүрэг гүйцэтгэснийг хятадын түүхчид өнөө ч нууж чадахгүй байна.

<sup>1</sup> Hu Seng. Imperialist and Chinese politics. Foreign Language Press. Beijing. 1981. P. 309.

<sup>2</sup> Газета «Власть труда», 1924.1.11.

Манай хувьд бол энэ хэлэлцээрт гарын үсэг зурснаар умард хятадын цэргийн эрхтний шууд зэвсэгт халдлагын аюул намжсан гэж үздэг байна. Нөгөө талаар Монголд бүгж байсан цагаантныг нэгэнт хөөж дуусгасан учир ЗСБНХУ, БНМАУ-ын харилцан тохиролцсон үндсэн дээр Улаан Цэргийн ангиудыг 1925 оны 3-р сард хугацаанаас нь өмнө гаргасан байна<sup>3</sup>. Энэ тухай нот бичгийг 1925 оны 3-р сарын 12-нд Бээжинд суугаа онц бүрэн эрхт элчин сайд Карахан хятадын засгийн газарт гардуулсан бөгөөд уг нот бичгийн төгсгөлд «ах дүү хоёр орны хоорондох харилцааны асуудлыг хятадын засгийн газар эрхбиш монгол ард түмэнтэй энх тайван хэлэлцээний замаар шийдвэрлэж байхсан болуу гэж найдаж байна»<sup>4</sup> гэжээ.

Зөвлөлт-хятадын хэлэлцээрийн үзэл санааг МАХН-ын III их хурал зарчмын хувьд талархсан байна. Их хуралд олон улсын ба Монгол улсын гадаад байдлын тухай тавьсан илтгэлд: «Энэхүү гэрээ тогтоосон учир утга бол Дундад улсыг эзэрхсэн гадаадын эзэрхэг түрэмгий улсуудын хооронд харшлах, эвдрэлцэх өө сэв эрж, Хятадыг чингиж хуваагдан дарангуйлагдаж, залгигдан буй аюулаас гаргаж тэтгэсүгэй гэсэн учир буюу»<sup>5</sup> гээд цааш нь уг хэлэлцээр нь Зөвлөлт, Хятадын анхны тэгш эрхтэй гэрээ бөгөөд хоёр орны ард түмний эрх ашигт нийцсэн учир харилцан баяртайгаар хүлээн авсан тухай дурдсан байна.

Зөвлөлт-хятадын 1924 оны 5-р сарын 31-ний хэлэлцээртэй холбогдуулж нэгэн зүйлийг дурдахад үүний өмнөх жил буюу 1923 оны 1-р сарын 26-нд Сун Ятсен ба Зөвлөлт Оросын төлөөлөгчийн хамтран нийтэлсэн тунхагийн 4-р зүйлд Зөвлөлт Оросын засгийн газар Монголд империалист зорилго тавихгүй, Монгол нь үндэстний өөртөө засах зарчмын үндсэн дээр хувь заяагаа шийдэж болох тухай заасан байна.

Монголын төлөөлөгчийг 1924 оны 1-р сарын 20-нд Сун Ятсен хүлээж авах үедээ «Монгол эдүгээгээс эхлэн тусгаар тогтносон улс» гэж зарласан<sup>6</sup> бөгөөд мөн онд БНМАУ-ыг байгуулагдсаны дараа түүнийг Кантоны засгийн газар хүлээн зөвшөөрч, түүнчлэн Коминтерний Гүйцэтгэх Хороо Монголын хувьсгалчдын тусламжтайгаар Сун Ятсентэй холбоо тогтоосон тухай зэрэг сонин мэдээ байдаг байна. Гэвч эдгээр нь цаашид судалж тодруулуштай судалгааны сэдэв юм.

МАХН-ын III их хуралд олон улсын ба Монгол улсын гадаад байдлын талаар Төв Хорооны тэргүүлэгч гишүүн Ринчиний Элбэгдорж (Ринчино) тавьсан илтгэлдээ: «Дундад иргэн улс бол эрт, орой алин боловч тогтнож, нэгдэх цаг хэзээд ирнэ. Тэр цагт тэд нар амьсгал ухаан олмогц зэр зэвсгийг барьж, хүчийг зузаатган манай Монгол улсыг хуучин хэвээр залгиж эзэрхсүгэй хэмээн халдаар ирэх нь лав болно. Гэвч тэдний нэгдэх, тогтнох хэрэг нэлээд өдий. Тиймийн тул манай улс энэ завдлыг завшаад эсэргүүцэх хүчин чадлыг бүртгэж чадвал тэрхүү зүйлээс төдий л эмээх явдалгүй болох хэдэн зүйлийн баримт нь: 1. Ардын цэрэг, 2. Эх оронч үзэл, ухамсар, 3. Холбоотон

<sup>3</sup> 1924 оны 5-р сарын 31-ний хэлэлцээрийн 5-р зүйлд дурдсанаар бол Монголоос цэрэг гаргах асуудлыг тусгай бага хурлаар хэлэлцэн шийдвэрлэх ёстой байв. (Э.П.)

<sup>4</sup> Советско-Китайские отношения. 1917—1957, М., 1959, с. 102. док. № 62.

<sup>5</sup> Монгол Ардын Намын гуравдугаар их хурал. 1924 оны найм-есдүгээр сар. Дэлгэрэнгүй тэмдэглэл. Улаанбаатар. 1966. 29-р тал.

<sup>6</sup> Пын Мин. История Китайско-советской дружбы. (Перевод с Китайского) М., 1959, с. 114.

ЗХУ буй. 4. Хятадын гарт дарлагдан боолчлогдож байгаа монголчуудын хувьсгалт хөдөлгөөн болно»<sup>7</sup> гэжээ. Үүнээс гадна Турк, Перс, Афганистан гуравтай харилцаа тогтоож харилцан найрамдах нь зүйтэй, машин техник олж авахад Герман ашигтай гэж үзэж байжээ. МАХН-ын III их хурлын үед монгол-хятадын харилцаа, манай дорнод хилийн асуудал анхаарлын төвд байсан ба тэгэхээс ч өөр аргагүй байсан нь илт байжээ. Зөвхөн нэг жишээ болгож намын III их хуралд оролцож баяр хүргэсэн Баргын төлөөлөгч Буянгэрэл (Фуминтай)-ийн хэлсэн үгнээс үзэхэд Өвөр ба Барга монголчууд хятадын харгисуудын гарт удтал нухлагдаж, хятадын харгис Чжан Цзолин Монголыг залгихаар өвөр монгол хятад цэргийг олон мянгаар нь бөөгнүүлж буйн дээр Жи Бин (Япон—Э.П.) улс Монголын эсрэг эзлэн түрэмгийлэх хорт бодлого агуулж байжээ. Хятадын 1925—1927 оны хувьсгалын дараах үеэс эхлэн Алс Дорнод дахь Японы бодлого эрс идэвхжиж байв.

1924 оны 10-р сард хуралдаж эхэлсэн улсын анхдугаар их хуралд ерөнхий сайд Б. Цэрэндорж хятадын бодлогын талаар хэлэхдээ тэд «бидний монголын газар, дэлхийг булаан эзлэх ба шашин үндсийг сөнөөх хорт бодлого хэдийгээр их боловч хараахан нааш хандах чөлөө завдлыг олж чадаагүй билээ»<sup>8</sup> гээд гадаадад ЗСБНХУ, Коминтернээс өөр тустай нөхөр огт үгүй гэж онцлон тэмдэглэжээ.

Намын Төв Хорооны дарга Ц. Дамбадоржийн илтгэлд: «Эдүгээ манай дайсан хэн хэмээвээс хятадын харгис эзэрхэг түшмэл цэрэг бөгөөд тэдэнтэй эсэргүүцэх хүчийг завдан бүртгэхийг хичээвээс зохино»<sup>9</sup> гээд гагцхүү хятадын гэмгүй ард түмэн, ялангуяа хятадын ажилчин анги, түүний намтай холбоогоо зузаатгахыг заасан байна.

Улсын анхдугаар их хуралд ГЯЯ-ны сайд Амарын тавьсан илтгэлд хятадын дотоод үймээн самуун, иргэний хувьсгалт дайны явц, түүний шалтгааныг империалист гүрнүүдийн харгис бодлоготой холбож тайлбарлахын зэрэгцээ Хятадын хувьд баримтлах бодлогыг дор дурдсан маягаар тодорхойлжээ. Үүнд: «Одоо манай Монгол ардын засгийн газар ба олон түмэн ардууд бүрэн эрхтэй улс төр байгуулсан бөгөөд үүнд манай ардын засгийн газар болбаас Дундад улс лугаа эрхтэнээ найрамдаж хоёр этгээдийн олон түмэн ардыг тус тус энх амраар аж төрүүлэхийг хүсэх боловч гагцхүү Дундад улсын засгийн газраас:

1. Манай Монгол улсыг бүрэн эрхтэй тусгаар тогтносон улс болсныг зөвшөөрөн хүлээх,
2. Манай Монголын бүхий л хохирсон зүйлийг бүрнээ төлөн өгөх,
3. Дотоод чуулганы зэрэг Монгол овогтонд автономийн эрхийг олгох,
4. Орос улсын төлөөлөгчийг хуралд гэрч болгон суулгаж хэлэлцэх,
5. Мөнхүү хэлэлцээг Хүрээнд нээхийг зөвшөөрөх аваас манай ардын засгийн

газраас даруй бүрэн эрх барих төлөөлөгч нарыг томилон хэлэлцээ нээхийг зөвшөөрнө»<sup>10</sup> гэжээ. Ийм болзол, шаардлагыг манай засгийн газар ЗХУ-аар дамжуулан хятадын талд урьд нь ч тавьж байсан ба 1924 онд ч тавьж байсан нь илтгэлээс тодорхой харагдаж байна.

Их хурлын тогтоолоос үзэхэд 1921 оны Монгол, Зөвлөлтийн найрамдлын гэрээг батлаад Дундад улсын ард түмэнтэй холбоо, найрам-

<sup>7</sup> Монгол Ардын Намын III их хурал. УБ., 1966, 30-р тал.

<sup>8</sup> Улсын их хурлын сонин. 1924. Тэргүүн дэвтэр. 10-р тал

<sup>9</sup> Мөн тэнд. 16-р тал.

<sup>10</sup> Улсын их хурлын сонин. 1924.12.7. 1-р дэвтэр. 4-р тал.

дал байгуулахыг хичээн, бүх Монгол угсаатанд эрх чөлөө олгох зэрэг асуудлыг тухайн байдалд нийцүүлэн тавьж шийдвэрлэхийг зорьж байжээ. Түүнчлэн гадаадын харьяат нарыг ялган салгаж шударга хэсгийг нь хамгаалж, ихэнхийг нь нутагт нь явуулж байсныг сайшаан баталж, хятад иргэдийг цөөтгөх, нэмж ирэхийг нь хязгаарлах нь зүйтэй гэж үзэж нарийн чанга дүрэм боловсруулж дагаж мөрдөхөөр тогтжээ.

Хятадын байдлын талаар манай намын III, Улсын анхдугаар их хурлаас хийсэн дүгнэлт үндсэндээ зөв зүйтэй байсныг хойших үйл явдал нотолсон юм.

Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын анхдугаар их хурлаас 1925 онд олон түмэн ард нийтэд гаргасан тунхаглан зарлах бичигтээ Англи, Америк, Франц, Япон зэрэг гүрнүүд Хятадад ноёрхлоо тогтоохыг эрмэлзэж, дотоод Монголд Япон төмөр зам зэрэг барилга байгууламж шамдан барьж буй ийм үед «гагцхүү Зөвлөлийн Засагт Холбоот улс ба ардын хувьсгалт гадаад Монгол нь дарлагдсан бага буурай улсын нөхөр хань болж байна. Учир нь энэхүү хоёр улсад ардын эрх тогтсоор нэлээд удаж хүчийг олсон болой»<sup>11</sup> гэжээ. Дотоод Монголын Ардын Хувьсгалт нам үндэснийхээ эрх чөлөөний тэмцлийг нэг үндэстний явцуу хүрээнд биш нийт хятадын олон үндэстэн, түүний дотор хятад үндэстний эрх чөлөөний төлөө тэмцэлтэй хослуулан үзэж байсан нь энд харагдаж байна.

ДМАХН бас үндэсний эрх чөлөөний тэмцлийг нэг талаас гадаадын империалист хүчний эсрэг, нөгөө талаас дотоодын дарлал мөлжлөгийн эсрэг чиглүүлж байлаа.

Энэ нь ганц Өвөр Монгол биш, ер нь 1925—1927 оны хятадын хувьсгалын нийтлэг шинж юм. Энэ талаар Хятадын Коммунист намын зүтгэлтэн Цюй Цюбо (1899--1935) Хятадын 1925 оны «5-р сарын 30»-ний хөдөлгөөний туршлага дээр үндэслэн үндэсний хувьсгалын явцад үндэсний чөлөөлөх хөдөлгөөн нь хятадын дарлагдаж мөлжигдсэн ангиудаас империализмын эсрэг явуулж байгаа ангийн тэмцэл төдийгүй дотоодын хөрөнгөтний эсрэг явуулж буй ангийн тэмцэл<sup>12</sup> гэдгийг тодорхой ойлгож тууштай сурталчилж байжээ.

20-иод оны дундаас өрнөсөн хятадын хувьсгал, түүний дотор Өвөр Монголын ард түмний үндэсний чөлөөлөх хөдөлгөөнийг дэмжихийн учир үүнд байсан бөгөөд түүнийг монголын ард түмэн, БНМАУ-ын засгийн газар, МАХН бүх талаар талархан дэмжсэн түүхтэй. Харин манай талын ийм интернационалч тус дэмжлэг хятадын ард түмний эрх ашигт яв цав нийцэж, тэд баяртай угтаж байсан боловч уг дэмжлэг янз бүрийн саад бэрхшээлтэй тулгарч байлаа. Ийм саад тотгорыг гадаадын империалистүүд, тэдний хань хамсаа болсон хятадын хөрөнгөтөн, харгис цэргийн эрхтэн, үндэсний урвагч феодал ноёдууд учруулж байсан юм.

Капиталист биш хөгжлийн замыг сонгож авсан Монгол Ардын Хувьсгалт намын III их хурлын талаар энэ өгүүлэлд яригдаж байгаа болохоор хятадын маоист удирдлага капиталист биш хөгжлийн замын асуудалд хэрхэн ханддагийг энд товч боловч дурдах нь зүйтэй. Урьд өмнө колони болон хараат байсан орнууд капиталист биш замаар хөгжиж болох тухай Лениний сургаалыг хятадын удирдлага шууд үгүйс-

<sup>11</sup> Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын нэгдүгээр их хурлаас олон түмэн ард нийтэд тунхаглан зарлах бичиг. УБ., 1925, 8, 16-р тал.

<sup>12</sup> Цюй Цюбо. Публицистика разных лет. (Перевод с Китайского) М., 1979. с. 235

гэж, тийм орнуудыг шууд «пролетарийн хувьсгал» хийж, «пролетарийн диктатур» тогтоохыг нэг үе шаарддаг байв. Ингэснээр маоистууд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний онолын хувьд баруун ревизионист алдаанаас «зүүний» адал балмад алдаанд шилжсэн юм.<sup>13</sup> Тэд манай улс 60 гаруй жил замнан хөгжиж өнөөгийн хөгжил дэвшилд хүч социализмыг амжилттай байгуулж байгаа монголын түүхэн туршлагыг гүтгэн гуйвуулсан өгүүллийг 1963 оноос эхлэн нийтэлж байв. Монголын «капиталист бус зам сүйрлээ»<sup>14</sup>, түүний капиталист бус замын туршлага нь «Ази, Африк, Латин Америкийн ард түмэнд эсрэг талын жишээ болж байна»<sup>15</sup> гэж бичиж байлаа.

Монгол Ардын Хувьсгалт Намын III Их хурал, манай улсын анхдугаар их хурлаас гадаад бодлогын талаар өгсөн дүгнэлт, дэвшүүлсэн чиг шугам нь үндэсний тусгаар тогтнолоо сахин хамгаалах баталгаа бол ЗХУ-тай тогтоосон ах дүүгийн найрамдал бөгөөд харин бусад аль ч улс орон, түүний дотор хөрш Хятад улстай харилцан бие биеийн бүрэн эрх, тусгаар тогтнолыг хүндэтгэх, тэгш эрхийн үндсэн дээр хэвийн харилцаа тогтоохыг чухалчилж байгаа ба гагцхүү тийм бодлого л аль аль ард түмний амин чухал эрх ашигт нийцэх ёстойг тодорхойлсонд оршино.

МАХН, БНМАУ-ын энх тайванч, интернационалч гадаад бодлого 60 жилийн өмнө ч дэлхийн хувьсгалт хөдөлгөөн, түүний дотор Ази, Алс Дорнод дахь улс түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж байсан, одоо ч гүйцэтгэсээр байна.

## **ВНЕШНЕЕ ПОЛОЖЕНИЕ МОНГОЛИИ В ПЕРИОД III СЪЕЗДА МНРП: ИСТОРИЯ И СОВРЕМЕННОСТЬ**

### **(Р е з ю м е)**

Внешнее положение Народной Монголии в период III съезда МНРП (август 1924 г.) определялось борьбой двух противоположных миров—мира социализма и мира капитализма, сложившейся международной обстановкой того времени на Дальнем Востоке. Как известно, 1924-й год явился годом признания СССР большим количеством капиталистических государств. С подписанием в мае 1924 года «Соглашения об общих принципах урегулирования вопросов между Союзом Советских Социалистических Республик и Китайской Республикой» установились дипломатические отношения между этими двумя соседними государствами.

III съезд МНРП одобрил советско-китайское Соглашение как равноправный и взаимовыгодный договор, уважающий суверенитет друг друга и имеющий важное значение в защите коренных интересов

<sup>13</sup> Б. В. Поспелов. Маоизм и мировое революционное движение: М., 1979: с. 121.

<sup>14</sup> «Жэньминь жибао» 1967.5.17.

<sup>15</sup> Мөн сонин. 1977.9.14

китайского народа в противоположность политике «открытых дверей и равных возможностей», которую проводили империалистические державы в отношении Китая. Съезд положительно оценил нормализацию советско-китайских отношений. Вместе с тем он отвергнул претензию Китая на Монголию и указал на её несостоятельность. Автор статьи, ссылаясь на документы того периода, критикует позицию пекинского правительства и Японии, которые отрицали государственный суверенитет Народной Монголии. В статье также раскрывается твердая принципиальная позиция МНРП и правительства МНР, занятая ими в вопросе о защите государственного суверенитета монгольского народа.

III съезд МНРП еще раз подтвердил готовность Народной Монголии начать с Китаем переговоры о налаживании монголо-китайских отношений на основе признания Китаем ее государственного суверенитета и государственную независимость МНР

В заключительной части статьи автор пишет об интернациональной помощи и поддержке, оказанной МНРП, правительством МНР и монгольским народом совместно с СССР и советским народом революционным силам Китая в период китайской революции 1925—1927 гг. Он также подвергает справедливой критике маоистское искажение исторического опыта некапилистического пути развития МНР и подчеркивает его большое международное значение на нынешнем этапе социального прогресса человечества.